



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 8/172

Хэрлэн сум

Н.Баярсайханыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 тогтоолын 10 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл тогтоогдоогүй тул Нармандахын Баярсайханыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн даргаар 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс ажилд томилсугай.

2.Н.Баярсайханы сарын үндсэн цалинг ТҮ-10 зэрэглэлээр тогтоон, 1,286,000 (нэг сая хоёр зуун наян зургаан мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Н.Баярсайханд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА